



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЗАЯАБАЛ ТАНАА

2019. 03. 25 № 01/580
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ болон жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Татварын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Заяабал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 25-наас 2019 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Сэржмядаг, Г.Мөнхчимэг нар гүйцэтгэв.

Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/632 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх журам,



түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Татварын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд орших ба төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх, гэж тодорхойлсон байна.

Татварын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлд Татварын ерөнхий газрын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Татварын ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.



2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Татварын ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд боловсруулж баталсан нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй дараах асуудлыг тусгах нь шаардлагатай байна.

- ✚ Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- ✚ Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- ✚ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- ✚ Нягтлан бодох бүртгэлийн программ ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого.

Татварын ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Татварын ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” программ хангамж ашигладаг байна.

Татварын ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ. Үүнд:

- ✚ Байгууллагын дарга ажлаа өгч дэд дарга түр орлон гүйцэтгэж байгаа;
- ✚ Ерөнхий нягтлан бодогч шинээр томилогдож 4 сар ажиллаад ажлаа өгсөн;
- ✚ Тооцооны нягтлангууд солигдсон зэргээс шалтгаалан аудитын явцад олон дахин санхүүгийн тайланг засварласан, санхүүгийн нэгтгэсэн тайланд тавих дотоод хяналт сул, үр нөлөөгүй байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Татварын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.



2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь тухайн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг тул зардлыг сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 40,225.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 402.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл дунд, дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзсэнтэй холбоотой юм Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 33 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 29 санхүүгийн тайлан аудитад хамрагдаж 4 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	27	2	4	
2	ТӨААН				
Дүн		27	2	4	0

Аудитаар 24 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 3 санхүүгийн тайланд “Хязгаарлалтай” санал дүгнэлт гаргасан байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 975.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 62.3 хувь буюу 608.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.7 хувь буюу 6.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 28.2 хувь буюу 275.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 8.8 хувь буюу 85.8 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 499.9 сая төгрөгийн алдааг залруулсан бөгөөд төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 108.4 сая төгрөгийн алдааг залруулсан болно.



Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	41	367.5	4	6.5	7	275.2	30	85.8	-	-	-	-
2	ТӨААН												
3	ТТЗ	1	-	-	-	1	-	1		-	-	-	-
Дүн		42	367.5	4	6.5	8	275.2	31	85.8				

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний, анхаарал татахуйц дараах алдаа зөрчилтэй асуудал байна. Үүнд:

- Өмнөх оны аудитаар тогтоосон актыг төсвөөс төлсөн, анхан шатны нотлох баримтгүй зардал гаргасан, шатахууны зардал баримтаар нотлогдоогүй, ээлжийн амралтыг давхардуулан цалин олгосон гэх зэрэг 6.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. /Сонгино хайрхан дүүргийн татварын хэлтэс 3.4 сая, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс 1.4 сая, Налайх дүүргийн татварын хэлтэс 0.8 сая, Дорнод аймгийн татварын хэлтэс 0.9 сая төгрөг/
- Тооцоо нийлсэн актгүй он удаан жил болсон авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй, бараа материалын тайлан гаргаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн, шүүхийн шийдвэрийн нэхэмжлэлийг төсвөөс төлсөн, үндсэн хөрөнгийг дансанд тусгаагүй, шатахууны зардлын холбогдох тооцоог хийгээгүй, төсвийн хөрөнгөөр баяр ёслолын арга хэмжээ тэмдэглэсэн, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, томилолтын зардлын анхан шатны баримт дутуу зэрэг нийт 275.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна. /Нийслэлийн татварын хэлтэс 31.0 сая, Баянзүрх дүүргийн татварын хэлтэс 131.5 сая, Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс 23.8 сая, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс 21.8 сая, Хан-Уул дүүргийн татварын хэлтэс 60.0 сая, Налайх дүүргийн татварын хэлтэс 4.9 сая, Төв аймгийн татварын хэлтэс 2.0 сая /

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:



Орон тоотой холбоотой асуудал

Асуудал 1:

Сангийн сайдын 2016 оны 301 дүгээр тушаалаар Татварын ерөнхий газар болон харьяа хэлтэс, нэгжүүдийн орон тооны дээд хязгаарыг 1823 байхаар баталсан боловч 2017 онд 88, 2018 онд 76, 2019 оны 3 дугаар сарын байдлаар 48 орон тоогоор тус тус хэтрүүлэн ажилласан байгаа нь Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д "Агентлагийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 8.3.4-д "батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэл:

Хууль, дүрэм журам мөрдөгдөхгүй байх, зардал нэмэгдэх, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх.

Шийдэл:

Хууль, журам, дээд шатны тушаал шийдвэрийг хэрэгжүүлж батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллахгүй байх, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Татварын ерөнхий газрын дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар орон, тоо цалин, үндсэн хөрөнгийн дансанд горим сорил хэрэгжүүлэн авч үзэж анхаарал хандуулна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Татварын ерөнхий газрын 2018 оны төсвийн 30,201.9 сая төгрөгийг улсын төсвөөс, өөрийн орлогоос 2,150.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр батлагдсан байна.

Улсын төсвөөс 30,201.9 сая төгрөгийн санхүүжилтыг 100 хувь олгосон ба өөрийн орлогоос 3,830.1 сая төгрөг бүрдүүлж төлөвлөгөөг 1,680.1 сая төгрөгөөр буюу 78.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Мөн урсгал зардалд 32,096.6 сая төгрөг зарцуулж 99.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба санхүүжилтийн үлдэгдэл болон өөрийн орлогоос 1,943.7 сая төгрөг Төв төрийн санд буцаан төвлөрүүлжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг "shilendans.gov.mn" цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж цахим хуудсандаа шилэн данс цэсээр дамжуулан "shilendans.gov.mn" цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Дараа төсвийн төсөл /Бүтэн жилээр/
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /Хагас, бүтэн жилээр, сар улирал бүр/
- Тухайн жилийн төсөв орсон нэмэлт, өөрчлөлт /Тухай бүр/
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан /Хагас, бүтэн жилээр/



- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /Тухай бүр/
- Санхүүгийн тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /Бүтэн жилээр/
- Байгууллагын батлагдсан төсөв /Бүтэн жилээр/

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 68.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 зөвлөмж өгснийг 2018 оны жилийн эцсийн байдлаар 94.7 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Татварын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Татварын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Улсын төсвийн орлого хяналтын газар 4.4 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зардлыг бүртгэл тайланд тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх, санхүүгийн тайланд бүртгэлээр тавих хяналт сул байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал бүртгэл тайланд тусгахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Улсын төсвийн орлого хяналтын газар ТӨБЗГ-ын зөвшөөрөл болон Татварын ерөнхий газрын даргын тушаалаар 236.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахдаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн шийдвэр гаргаагүй, хөрөнгө устгасан акт үйлдээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан



хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална", 31.3.1-д "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдаагүй,

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

3.3 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн, анхан шатны баримт бүрдэлгүй ажил, гүйлгээ хүлээн зөвшөөрч бүртгэсэн, өмнөх оны кассын зарцуулалтыг тайлант онд тусгасан, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь үнэн зөв, тохиолдсон байх батламж мэдэгдэл хангагдаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна

3.3.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, бараа материал, зардалд бүртгэлээр тавих хяналт сул байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хууль, дүрэм журам хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гарахгүй байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

3.4 Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 33 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 24 санхүүгийн тайланд зөрчилгүй, 3 санхүүгийн тайлан хязгаарлалттай, 4 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 2 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 867.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 499.9 сая төгрөгийн алдааг залруулж 6.5 сая төгрөгийн акт тогтоож, 275.2 сая төгрөгийн албан шаардлага, 85.8 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:



Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,267,129.6	4,568,693.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	525,678.4	865,844.3
АВЛАГА	1,789,825.0	1,791,157.3
УРЬДЧИЛГАА	132,203.1	49,259.3
БАРАА МАТЕРИАЛ	819,423.0	1,862,432.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,330,964.5	21,717,770.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,330,964.5	21,717,770.2
Биет хөрөнгө	14,862,288.8	18,399,615.1
Биет бус хөрөнгө	2,468,675.7	3,318,155.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,598,094.1	26,286,463.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	125,290.8	2,227,695.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	125,290.8	2,227,695.7
Өглөг	125,290.8	2,227,695.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,472,803.3	24,058,768.0
Засгийн газрын хувь оролцоо	20,472,803.3	24,058,768.0
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	18,877,901.2	20,017,342.1
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-
Хуримтлагдсан үр дүн	(584,061.7)	(80,858.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,178,963.8	4,118,117.9
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	4,166.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,598,094.1	26,286,463.7



4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	38,311,091.4	40,547,245.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,970,797.8	4,686,437.5
Нийтлэг татварын бус орлого	3,970,797.8	4,680,458.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	5,978.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	34,340,293.6	35,860,808.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	37,617,181.1	39,768,308.1
УРСГАЛ ЗАРДАЛ	37,617,181.1	39,768,308.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,125,709.7	35,639,564.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,040,917.6	22,361,291.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,417,365.2	2,667,650.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,329,131.8	1,286,921.6
Хангамж, бараа материалын зардал	1,176,702.9	996,504.0
Нормативт зардал	36,902.5	2,577.6
Эд хогшил, урсгал засварын зардал	173,388.6	186,429.1
Томилолт, зочны зардал	150,355.8	199,458.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,451,683.2	5,447,023.4
Бараа үйлчилгээний бусад зардал	2,349,262.2	2,491,709.1
ХҮҮ	-	-
ТАТААС	-	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,491,471.4	4,128,743.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	693,910.3	778,937.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	224,160.3	349,043.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	469,750.0	429,894.2



4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	78,919,984.0	139,002,139.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,378,279.5	4,379,199.0
Нийтлэг татварын бус орлого	3,378,279.5	4,379,199.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	75,541,704.6	134,622,940.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,248,170.8	135,637,031.4
УРСГАЛ ЗАРДАЛ	77,248,170.8	135,637,031.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,388,658.0	33,506,861.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,255,857.8	22,305,859.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,312,682.7	2,648,179.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,335,455.5	1,293,778.1
Хангамж, бараа материалын зардал	1,001,632.3	979,697.9
Нормативт зардал	58,561.3	63,612.1
Эд хогшил, урсгал засварын зардал	284,988.2	352,459.4
Томилолт, зочны зардал	162,113.9	204,271.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,559,642.9	5,070,956.5
Бараа үйлчилгээний бусад зардал	417,723.2	588,046.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,859,512.8	102,130,169.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,671,813.3	3,365,107.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,659,007.0	3,024,941.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,659,007.0	3,024,941.9
Дотоод эх үүсвэрээр	1,659,007.0	3,024,941.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,659,007.0)	(3,024,941.9)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	12,806.3	340,165.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	512,872.1	525,678.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	525,678.4	865,844.3



4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,927,196.6		17,927,196.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,086,765.3		2,086,765.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,013,961.8		20,013,961.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(10,908.6)		(10,908.6)
Тайлант үеийн үр дүн	469,750.0		469,750.0
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,472,803.3		20,472,803.3
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,472,803.3		20,472,803.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	185,373.2		185,373.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,658,176.4		20,658,176.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,086,665.4		3,086,665.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	429,894.2		429,894.2
Тайлант үеийн үр дүн	429,894.2		429,894.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,058,768.0		24,058,768.0



4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт -, хэмнэлт +	Гүйцэтгэл ийн хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,851,951.3	34,584,401.1	267,550.2	99.2
УРСГАЛ ЗАРДАЛ	32,351,951.3	32,096,101.2	255,850.1	99.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,324,381.3	31,067,798.9	256,582.4	99.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,218,314.0	21,086,006.3	132,307.7	99.4
Үндсэн цалин	13,855,821.2	14,270,848.6	(415,027.4)	103.0
Нэмэгдэл	4,219,740.9	3,680,710.3	539,030.6	87.2
Унаа хоолны хөнгөлөлт	1,128,325.0	1,068,602.9	59,722.1	94.7
Урамшуулал	2,014,426.9	2,056,564.8	(42,137.9)	102.1
Гэрээт ажлын хөлс	-	9,279.7	(9,279.7)	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,548,956.5	2,515,371.8	33,584.7	98.7
Тэтгэврийн даатгал	1,702,025.5	1,818,560.9	(116,535.4)	106.8
Тэтгэмжийн даатгал	211,732.8	172,550.9	39,181.9	81.5
ҮОМШӨ-ний даатгал	169,386.2	136,339.4	33,046.8	80.5
Ажилгүйдлийн даатгал	42,346.6	42,716.7	(370.1)	100.9
Эрүүл мэндийн даатгал	423,465.4	345,204.0	78,261.4	81.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,311,941.5	1,289,817.1	22,124.4	98.3
Гэрэл, цахилгаан	179,939.3	177,915.5	2,023.8	98.9
Түлш, халаалт	446,201.5	429,161.6	17,039.9	96.2
Цэвэр, бохир ус	52,213.6	51,755.4	458.2	99.1
Байрны түрээс	633,587.1	630,984.7	2,602.4	99.6
Хангамж, бараа материалын зардал	878,591.8	843,910.9	34,680.9	96.1
Бичиг хэрэг	231,673.8	243,739.3	(12,065.5)	105.2
Тээвэр, шатахуун	158,396.5	163,579.0	(5,182.5)	103.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	319,071.8	276,325.8	42,746.0	86.6
Ном, хэвлэл	27,387.5	17,764.7	9,622.8	64.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,291.6	20,726.0	6,565.6	75.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	114,770.6	121,776.2	(7,005.6)	106.1
Нормативт зардал	63,500.0	63,497.6	2.4	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000.0	1,997.6	2.4	99.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	61,500.0	61,500.0	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	278,060.3	277,310.8	749.5	99.7
Багаж, техник, хэрэгсэл	83,130.2	81,547.0	1,583.2	98.1
Тавилга	28,412.4	28,396.4	16.0	99.9
Урсгал засвар	166,517.7	167,367.4	(849.7)	100.5
Томилолт, зочны зардал	204,040.8	200,322.9	3,717.9	98.2
Дотоод албан томилолт	171,406.1	167,706.2	3,699.9	97.8
Зочин төлөөлөгч хүлээн авах	32,634.7	32,616.7	18.0	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,424,825.0	4,528,243.7	(103,418.7)	102.3



Татварын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,023,699.1	1,130,761.1	(107,062.0)	110.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,737.1	5,024.0	713.1	87.6
Даатгалын үйлчилгээ	26,129.8	24,999.7	1,130.1	95.7
Тээврийн хэрэгслийн татвар	4,623.3	3,637.1	986.2	78.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,092.5	2,107.5	(15.0)	100.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	829,762.9	829,118.6	644.3	99.9
Газрын төлбөр	2,117.0	1,932.4	184.6	91.3
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,530,663.3	2,530,663.3	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	396,151.4	263,317.8	132,833.6	66.5
Бараа үйлчилгээний бусад зардал	7,857.8	(123,967.6)	131,825.4	-1577.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	388,293.6	387,285.4	1,008.2	99.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,027,570.0	1,028,302.3	(732.3)	100.1
Бусад урсгал шилжүүлэг	1,027,570.0	1,028,302.3	(732.3)	100.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	107,409.8	105,977.5	1,432.3	98.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	721,008.2	721,008.2	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	199,152.0	201,316.6	(2,164.6)	101.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,500,000.0	2,488,299.9	11,700.1	99.5
Барилга байгууламж	2,000,000.0	1,350,000.0	650,000.0	67.5
Их засвар	500,000.0	487,799.9	12,200.1	97.6
Бусад хөрөнгө	-	650,500.0	(650,500.0)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,851,951.3	34,576,207.1	275,744.2	99.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,701,951.3	30,746,090.6	1,955,860.7	94.0
Улсын төсвөөс санхүүжих	32,701,951.3	30,746,090.6	1,955,860.7	94.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,150,000.0	3,830,116.5	(1,680,116.5)	178.1



Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Татварын ерөнхий газар			САГ-2019/01/СТА-ТТЗ	Сая төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Улсын төсвийн орлого хяналтын газар 4.4 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зардлыг бүртгэл тайланд тусгасан,	4.4	Зөвлөмж	Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Занданбат, Л.Бямбадорж,
Улсын төсвийн орлого хяналтын газар ТӨБЗГ-ын зөвшөөрөл болон ТЕГ-ын даргын тушаалаар 236.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахдаа өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргаагүй, хөрөнгө устгасан акт үйлдээгүй,		Зөвлөмж		
Бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн, анхан шатны баримт бүрдэлгүй ажил, гүйлгээ хүлээн зөвшөөрч бүртгэсэн, өмнөх оны кассын зарцуулалтыг тайланд онд тусгасан, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь үнэн зөв тохиолдсон байх батламж мэдэгдэл хангагдаагүй,	11.5	Зөвлөмж		
Төрийн үйлчилгээний ажилтнуудад тогтоосон хэмжээнээс илүү нэмэгдэл олгосон, гэрээт ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгосон, татварын улсын байцаагч нарт үр дүнгийн урамшуулал олгохдоо байгууллагын дотоод журмыг мөрдлөг болгоогүй,	22.4	Зөвлөмж		
Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 33 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 24 санхүүгийн тайланд зөрчилгүй, 3 санхүүгийн тайлан хязгаарлалттай, 4 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 2 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 867.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 499.9 сая төгрөгийн алдааг залруулж 6.5 сая төгрөгийн акт тогтоож, 275.2 сая төгрөгийн албан шаардлага, 85.8 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна,	329.2	Зөвлөмж		
Сангийн сайдын 2016 оны 301 дүгээр тушаалаар Татварын ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг нийт 1823 байхаар баталсан боловч 2017 онд 88, 2018 онд 76, орон тоогоор тус тус хэтрүүлэн ажилласан.		Албан шаардлага		
Дүн	367.5			



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.